



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/85

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Жагсаалт батлах тухай” 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



231910277

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 19 өдрийн А/85  
дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих
1	Гудамж талбайн гэрэлтүүлэг /Хэнтий, Хэрлэн сум/	400.0	400.0
2	Хот тохижилтын тусгай зориулалтын автомашин /Хэнтий, Хэрлэн сум/	600.0	600.0
3	Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Баянмөнх сум/	50.0	50.0
4	Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний үргэлжлэл /Хэнтий, Хэрлэн сум/	1,000.0	500.0
	Нийт дүн	2,050.0	1,550.0